

ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАЙГУУЛЛАГЫН
АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН
ЦАГ УУРЫН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ 20-Р ЦАХИМ
ТЕЛЕ УУЛЗАЛТЫН ТАЙЛАН

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийн (АРАС) Цаг уурын мэдээлэл солилцооны 20 дугаар цахим-теле уулзалтад (Working Group (MET/IE WG/20)) ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны байцаагч Д.Маасүрэн, Нислэгийн цаг уурын төвийн Ерөнхий технологич инженер Б.Сүхбаатар, Дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Н.Басбиш, ахлах синоптик инженер Э.Байгалмаа нар 2022 оны 3 дугаар сарын 28-30-ны хооронд цахим хэлбэрээр оролцлоо.

Тус хурлын зорилго нь Ази, Номхон далайн бүсийн агаарын навигацийн төлөвлөлт, хэрэгжилтийн цаг уурын ажлын хэсэг нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ОУИНБ/-аас цаг уурын үйлчилгээний бодлого, төлөвлөгөөг тус бүсэд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүс нутгийн агаарын навигацийн үйлчилгээг үзүүлж буй цаг уурын хөгжлийн хандлага, бодлогыг нэгтгэх, цаг уурын үйлчилгээг нэгдмэл нэг болгох, хийж хэрэгжүүлж байгаа ажлын явц, асуудал хүндрэлийг шийдвэрлэх талаар хэлэлцэхэд чиглэсэн.

Уг уулзалтад Австрали, АНУ, Бутан, БНХАУ, Вьетнам, Бүгд Найрамдах Фижи Улс, Хонг Конг Хятад, Энэтхэг, Индонез, Япон, Лаос, Малайз, Макао, Мальдив, Монгол, Шинэ Зеланд, Пакистан, Филиппин, БНАСАУ, Сингапур, Шри-Ланка, Тайланд зэрэг нийт 21 орон болон Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO), Олон улсын агаарын тээврийн нисгэгчдийн холбоо (IFALPA)-ны 116 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.

Уулзалтын даргаар Австралийн Цаг уурын албаны Нисэхийн үйлчилгээ, хөгжлийн газрын бүсийн менежер Mr. Tim Hailes удирдан явуулсан бөгөөд уулзалтыг Ази, Номхон далайн бүсийн мэргэжилтэн Mr. Peter C. Dunda нээж үг хэллээ.

Хурлаар 6 чиглэлээр 20 гаруй асуудал хэлэлцсэн бөгөөд Монгол Улсаас нисэхийн цаг уурын үйл ажиллагааны чиглэлээр хийгдэж буй ажил болох ROBEX Handbook, IWXXM-ын хэрэгжилтийн явц, мэдээлэх хуудсыг ахлах инженер Э.Байгалмаа танилцуулсан болно.

Хурлын үеэр цаг уурын үйлчилгээ, энэ чиглэлээр хийгдэж байгаа ажлын уялдаа, холбоотой үйл ажиллагаандаа нэн түрүүнд тусгавал зохих дараах асуудлууд яригдлаа. Үүнд:

- Өмнөх уулзалтуудын үр дүнгийн талаар хэлэлцэж, тулгамдсан асуудлуудыг яаралтай шийдвэрлэх;
- Бүс нутгийн ОРМЕТ мэдээлэл солилцооны схемийн бүтцийг оновчтой болгох санал, хөгжүүлэлт, тохируулалт;
- Улс орнуудын мэдээлэл харилцан солилцооны төлөвлөлт, хэрэгжилт, тухайлбал ОУИНБ-ын стандартын дагуу Цаг уурын мэдээлэл солилцооны

загвар IWXXM-ыг улс орнууд хэрхэн хэрэгжүүлсэн, хамтран ажиллаж, мэдээлэл солилцсон, тулгамдаж буй хүндрэлтэй асуудлууд болон одоогийн нөхцөл байдлын талаарх танилцуулга тавьж, санал солилцоо;

- Бүс нутгийн чанарын хяналт, мониторинг, цаг уурын мэдээлэл солилцооны менежментийн асуудлууд, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх;
- Цаг уурын мэдээлэл солилцооны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөмжөөр хангаж, сайжруулах;
- Цаашдын ажлын төлөвлөлт

Нислэгийн цаг уурын төвөөс тавигдсан 2 мэдээлэх хуудасны тухайд:

1. ОУИНБ-ын дүрмийн 3-р хавсралтын 78 дахь нэмэлт өөрчлөлтөд тусгагдсан SWIM концепцын хүрээнд цаг уурын мэдээлэл дамжуулалтын IWXXM 3.0-ийг хэрэгжүүлэх талаар хийгдсэн ажил, гарч буй зарим хүндрэл, мэдээлэл дамжуулах сүлжээ тоног төхөөрөмжийн суурилуулалт, холболтын тухай
2. Нисэхийн цахилгаан холбооны сүлжээ (AFTN)-ээр “Чингис хаан” ОУНБ-ын METAR мэдээг 30 минут тутам олон улсын мэдээ солилцоонд оруулах зорилгоор Ази, Номхон далайн орнуудын ROBEX handbook-ийн Beijing ROC-ын BUL No. SACI32 / FTCI32 багцаас BUL No. SACI31 / FTCI31 багцад шилжүүлэх

2.1 ROBEX handbook Focal Point-д НЦУТ-ийн дарга Б.Баньдсүрэнг Монгол Улсыг төлөөлсөн хариуцагчаар нэмүүлэх зэрэг асуудлын хөндөж тавьсан болно.

Энэ уулзалтаас дүгнэхэд Ази, номхон далайн бүсийн улс орнуудын агаарын навигацийн үйлчилгээ үзүүлж буй цаг уурын чиглэлээр хийгдэж байгаа ажлууд, төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаатай танилцаж Монгол улсын хувьд дээрх төсөл хөтөлбөрүүдэд оролцох, тухайн бүс нутгийн улс орнуудтай харьцуулах, туршлага судлах боломжийг бүрдүүлсэн, цаашдын бодлого, төлөвлөгөөг сайжруулахад маш том түлхэц өгсөн ач холбогдол бүхий уулзалт болсон төдийгүй манай улсад нэвтрүүлэхээр төлөвлөгдөж байгаа хөтөлбөрийн хүндрэлүүдэд хариулт авч цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгахад их хувь нэмэр болно.

Нислэгийн цаг уурын төв